



IAF Mandatory Document

ОУИФ Заавал мөрдөх баримт бичиг

**ISO/IEC 17021-1 СТАНДАРТЫН ХЭРЭГЛЭЭ:  
НЭГДСЭН МЕНЕЖМЕНТИЙН  
ТОГТОЛЦООНЫ АУДИТАД ОУИФ-ЫН  
ЗААВАЛ МӨРДӨХ БАРИМТ БИЧИГ**

**IAF MANDATORY DOCUMENT FOR THE  
APPLICATION OF ISO/IEC 17021-1 FOR AUDITS  
OF INTEGRATED MANAGEMENT SYSTEMS**

**Хэвлэл 3**

**(IAF MD 11:2023)**

Хэвлэсэн огноо: 12.09.2023

Хэрэгжиж эхлэх огноо: 12.09.2023

Олон Улсын Итгэмжлэлийн Форум (ОУИФ) нь ОУИФ-ын гишүүнээр итгэмжлэгдсэн Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ын гаргасан үр дүнг дэлхий даяар хүлээн зөвшөөрч, Итгэмжлэлийн байгууллага (ИБ)-уудын дунд дэлхий хэмжээний харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрийг хэрэгжүүлэх замаар үйлдвэрлэгч болон зохицуулагч байгууллагуудад дэмжлэг үзүүлэн худалдааг хөнгөвчилдөг.

Итгэмжлэл нь итгэмжлэгдсэн тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ)-ууд итгэмжлэлийн хамрах хүрээнд багтсан ажлаа гүйцэтгэх чадамжтайг батлах замаар бизнес болон тэдгээрийн хэрэглэгчдэд учрах эрсдэлийг бууруулдаг. ОУИФ-ын гишүүн ИБ болон тэдгээрийн итгэмжлэгдсэн ТҮБ-ууд нь олон улсын стандарт, тэдгээр стандартын хэрэглээний нийцтэй байдалд зориулсан ОУИФ-ын заавал дагаж мөрдөх баримт бичгийг мөрдөх шаардлагатай.

ОУИФ-ын Олон талт харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр (ХХЗХ)-т нэгдсэн ИБ-уудын итгэмжлэлийн хөтөлбөрийн үйл ажиллагаанд итгэлийг бий болгохын тулд ижил түвшний багаас бүрдсэн үнэлгээг тогтмол явуулдаг. ОУИФ-ын ХХЗХ-ийн бүтцийн талаар ОУИФ-ын бодлогын баримт бичиг 3 (IAF PL 3) “ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний бүтэц ба ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний өргөтгөлийн бодлого, журам”-д дэлгэрэнгүй тусгасан. Мөн ОУИФ-ын ХХЗХ-ийн хамрах хүрээний талаар ОУИФ-ын ХХЗХ-ийн статус баримт бичигт тусгасан.

ОУИФ-ын ХХЗХ-ийн нь дараах таван түвшний бүтэцтэй. Үүнд:  
1-р түвшин нь ISO/IEC 17011 стандартыг хэрэгжүүлэгч бүх ИБ-уудад хамаарах заавал мөрдөх шалгуурыг тодорхойлно. 2-р түвшний үйл ажиллагаа болон холбогдох 3-р түвшний норматив баримт бичиг(үүд)-ийн нэгдлийг ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээ

The International Accreditation Forum, Inc. (IAF) facilitates trade and supports industry and regulators by operating a worldwide mutual recognition arrangement among Accreditation Bodies (ABs) in order that the results issued by Conformity Assessment Bodies (CABs) accredited by IAF members can be accepted globally.

Accreditation reduces risk for business and its customers by assuring them that accredited CABs are competent to carry out the work they undertake within their scope of accreditation. ABs that are members of IAF and their accredited CABs are required to comply with appropriate international standards and IAF mandatory documents for the consistent application of those standards.

ABs that are signatories to the IAF Multilateral Recognition Arrangement (MLA) are evaluated regularly by an appointed team of peers to provide confidence in the operation of their accreditation programs. The structure of the IAF MLA is detailed in IAF PL 3 - Policies and Procedures on the IAF MLA Structure and for Expansion of the Scope of the IAF MLA. The scope of the IAF MLA is detailed in the IAF MLA Status document.

The IAF MLA is structured in five levels: Level 1 specifies mandatory criteria that apply to all ABs, ISO/IEC 17011. The combination of a Level 2 activity(ies) and the corresponding Level 3 normative document(s) is called the main scope of the MLA, and the combination of Level 4 (if applicable) and Level 5 relevant normative documents is called a sub-scope of the MLA.

гэж нэрлэдэг. 4-р түвшин (хэрэв байгаа бол) болон 5-р түвшний холбогдох норматив баримт бичгийн нэгдлийг ХХЗХ-ийн дэд хамрах хүрээ гэж нэрлэдэг.

- ХХЗХ-ийн үндсэн хамрах хүрээнд бүтээгдэхүүний баталгаажуулалт гэх мэт үйл ажиллагаа болон ISO/IEC 17065 зэрэг холбогдох заавал мөрдөх стандарт багтана. Үндсэн хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил найдвартай гэж үзнэ.
- ХХЗХ-ийн дэд хүрээнд тохирлын үнэлгээний шаардлагууд буюу ISO 9001 болон схемийн тусгай шаардлага, тухайлбал ISO 22003-1 стандартууд багтана. Дэд хамрах хүрээний түвшинд ТҮБ-ын хийсэн баталгааг ижил тэнцүү гэж үзнэ.

ОУИФ-ын ХХЗХ нь тохирлын үнэлгээний үр дүнг зах зээл хүлээн зөвшөөрөхөд шаардлагатай итгэлийг төрүүлдэг. ОУИФ-ын ХХЗХ-т гарын үсэг зурсан ИБ-аар итгэмжлэгдсэн байгууллагын ОУИФ-ын ХХЗХ-ийн хүрээнд гаргасан баталгааг дэлхий дахинд хүлээн зөвшөөрч, улмаар олон улсын худалдааг хөнгөвчилнө.

Хэвлэл 3

Боловсруулсан: ОУИФ-ын Техникийн хороо

Баталсан: ОУИФ-ын гишүүд

Огноо: 12.09.2023

Хэвлэсэн огноо: 26.07.2023

Хэрэгжиж эхлэх огноо: 12.09.2023

Холбоо барих: Элва Нилсен

ОУИФ Нарийн бичгийн дарга

Утас: +1 613 454-8159

И-мейл: [secretary@iaf.nu](mailto:secretary@iaf.nu)

- The main scope of the MLA includes activities e.g. product certification and associated mandated standards e.g. ISO/IEC 17065. The attestations made by CABs at the main scope level are considered to be equally reliable.
- The sub scope of the MLA includes conformity assessment requirements e.g. ISO 9001 and scheme specific requirements, where applicable, e.g. ISO 22003-1. The attestations made by CABs at the sub scope level are considered to be equivalent.

The IAF MLA delivers the confidence needed for market acceptance of conformity assessment outcomes. An attestation issued, within the scope of the IAF MLA, by a body that is accredited by an IAF MLA signatory AB can be recognized worldwide, thereby facilitating international trade.

Issue 3

Prepared by: IAF Technical Committee

Approved by: IAF Members

Date: 12 September 2023

Issue Date: 26 July 2023

Application Date: 12 September 2023

Name for Enquiries: Elva Nilsen

IAF Corporate Secretary

Contact Phone: +1 (613) 454 8159

Email: [secretary@iaf.nu](mailto:secretary@iaf.nu)

## **АГУУЛГА**

0. УДИРТГАЛ
1. ТОДОРХОЙЛОЛТ
2. ХЭРЭГЛЭЭ
3. АНХДАГЧ АУДИТ БА  
БАТАЛГААЖУУЛАЛТ
4. МАГАДЛАХ ХЯНАЛТ, ДАВТАН  
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ҮЙЛ  
АЖИЛЛАГАА
5. ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, БАГАСГАХ,  
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ

ХАВСРАЛТ 1 – АУДИТЫН ХУГАЦААГ  
БАГАСГАХ

## **TABLE OF CONTENTS**

0. INTRODUCTION
1. DEFINITIONS
2. APPLICATION
3. INITIAL AUDIT AND  
CERTIFICATION
4. SURVEILLANCE AND  
RECERTIFICATION ACTIVITIES
5. SUSPENSION, REDUCTION,  
WITHDRAWAL

ANNEX 1 – REDUCTION OF AUDIT TIME

## **ОУИФ-ЫН ЗААВАЛ МӨРДӨХ БАРИМТ БИЧГИЙН ТАНИЛЦУУЛГА**

Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байвал зохино” нэр томъёо нь шаардлагыг биелүүлнэ гэсэн утгыг илэрхийлнэ. Тохирлын үнэлгээний байгууллага (ТҮБ) нь итгэмжлэлийн байгууллагад (ИБ) нотлон харуулсан ижил аргаар эдгээр шаардлагыг биелүүлнэ. Энэ баримт бичигт хэрэглэгдэх “байх ёстой” нэр томъёо нь заавал мөрдөх холбогдох стандартын шаардлагыг заана.

## **INTRODUCTION TO IAF MANDATORY DOCUMENTS**

The term “should” is used in this document to indicate recognised means of meeting the requirements of the standard. A Conformity Assessment Body (CAB) can meet these in an equivalent way provided this can be demonstrated to an Accreditation Body (AB). The term “shall” is used in this document to indicate those provisions which, reflecting the requirements of the relevant standard, are mandatory.

**ISO/IEC 17021-1 СТАНДАРТЫН  
ХЭРЭГЛЭЭ: НЭГДСЭН  
МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ  
АУДИТАД ОУИФ-ЫН ЗААВАЛ  
МӨРДӨХ БАРИМТ БИЧИГ**

Энэхүү баримт бичиг нь баталгаажуулалтын байгууллага (ББ)-ууд Нэгдсэн Менежментийн Тогтолцоо (НМТ)-ны аудитыг төлөвлөх, явуулах буюу ISO/IEC 17021-1 стандартын 9.1.6 заалтыг тууштай хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай.

## **0. УДИРТГАЛ**

0.1. Энэхүү баримт бичиг нь НМТ-ны аудитыг төлөвлөх, явуулахад ISO/IEC 17021-1 стандартыг хэрэглэх, шаардлагатай бол байгууллагын менежментийг тогтолцоог хоёр буюу түүнээс дээш багц аудитын шалгуур/стандартаар баталгаажуулахад тавигдах шаардлагыг тусгасан болно. ISO/IEC 17021-1 стандартын бүх заалтууд хүчинтэй хэвээр байгаа бөгөөд энэхүү баримт бичиг нь уг стандартад тавигдах шаардлагуудын аль нэгийг нь орлохгүй.

0.2. Энэхүү баримт бичиг нь тухайн салбар/схемийн стандартаар тусгайлан хориглоогүй бол тухайн салбарын/схемийн стандартад хамаарах байж болно.

0.3. Энэхүү баримт бичгийн төгсгөлд байгаа хавсралт нь мөн шаардлагын нэг хэсэг бөгөөд тухайн байдлаар уншина гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

## **1. ХАМРАХ ХҮРЭЭ**

Энэхүү баримт бичгийн зорилгын үүднээс дараахь тодорхойлолтыг хэрэглэнэ. Үүнд:

**1.1 Нэгдсэн менежментийн тогтолцооны аудит:** Байгууллагын менежментийн тогтолцоог хоёр ба түүнээс дээш багц аудитын шалгуур/стандартуудын дагуу нэгэн зэрэг хийх аудит.

**IAF MANDATORY DOCUMENT FOR THE  
APPLICATION OF ISO/IEC 17021-1  
FOR AUDITS OF INTEGRATED  
MANAGEMENT SYSTEMS**

This document is mandatory for the consistent application of clause 9.1.6 of ISO/IEC 17021-1 by certification bodies (CBs) for planning and delivery of audits of Integrated Management Systems (IMS).

## **0. INTRODUCTION**

0.1 This document provides requirements for the application of ISO/IEC 17021-1 for the planning and delivery of audits of IMS and, if appropriate, the certification of an organization's management system(s) against two or more sets of audit criteria/standards. All clauses of ISO/IEC 17021-1 continue to apply and this document does not supersede any of the requirements in that standard.

0.2 This document may be applicable to sector-specific/scheme standards unless specifically prohibited by the sector-specific/scheme standard.

0.3 It shall be noted that the annex at the end of this document is also part of the requirements and shall be read as such.

## **1. DEFINITIONS**

For the purposes of this document, the following definitions apply:

**1.1 Audit of Integrated Management System:** An audit of an organization's management system against two or more sets of audit criteria/standards conducted at the same time.

**1.2 Нэгдсэн менежментийн тогтолцоо:** Нэгдмэл байдлын өгөгдсөн түвшин (1.3)-д нэгээс олон менежментийн стандартын шаардлагыг хангахын тулд байгууллагын гүйцэтгэлийн олон талыг удирдан чиглүүлдэг нэг менежментийн тогтолцоо. Менежментийн тогтолцоо нь аудитын шалгуур/стандарт тус бүрийн хувьд тусдаа менежментийн тогтолцоог нэмдэг нэгдсэн тогтолцооноос эхлээд нэг тогтолцооны баримт бичиг, менежментийн тогтолцооны элементүүд болон үүрэг хариуцлагыг хуваалцдаг Нэгдсэн менежментийн тогтолцоо хүртэл байж болно.

**1.3 Нэгдмэл байдлын түвшин:** Нэгээс олон менежментийн тогтолцооны стандартын шаардлагыг хангахын тулд байгууллагын гүйцэтгэлийн олон талыг удирдахын тулд нэг менежментийн тогтолцоог ашигладаг түвшин. Нэгдмэл байдал гэдэг нь менежментийн тогтолцоо нь хоёр буюу түүнээс дээш багц аудитын шалгуур/стандарттай холбоотой баримт бичиг, менежментийн тогтолцооны зохих элементүүд болон хариуцлагыг нэгтгэх чадвартай байхтай холбоотой юм.

*Тайлбар: Аудитын шалгуур нь тохирлын үнэлгээ, баталгаажуулалтын үндэс болгон ашигладаг менежментийн тогтолцооны стандартуудыг (жишээ нь: ISO 9001, ISO 14001, ISO/IEC 20000, ISO 22000, ISO/IEC 27001 гэх мэт) ойлгоход зориулагдсан.*

## 2. ХЭРЭГЛЭЭ

- 2.1 ББ нь дараахь зүйлсийг хангана. Үүнд:
- i) Аудитын хөтөлбөрийг бий болгохдоо менежментийн тогтолцоо(ууд)-н нэгдмэл байдлын түвшинг авч үзнэ.
  - ii) Аудитын төлөвлөгөө нь аудитын хамрах хүрээ болон чадамжтай аудитуруудад чиглэгдсэн менежментийн тогтолцооны

**1.2 Integrated Management System:** A single management system managing multiple aspects of organizational performance to meet the requirements of more than one management standard, at a given level of integration (1.3). A management system may range from a combined system adding separate management systems for each set of audit criteria/standard, to an Integrated Management System, sharing in single system documentation, management system elements, and responsibilities.

**1.3 Level of Integration:** The level to which an organization uses one single management system to manage multiple aspects of organizational performance to meet the requirements of more than one management system standard. Integration relates to the management system being able to integrate documentation, appropriate management system elements and responsibilities in relation to two or more sets of audit criteria/standards.

*Note: Audit criteria are intended to mean management system standards used as a basis for conformity assessment and certification (e.g. ISO 9001, ISO 14001, ISO/IEC 20000, ISO 22000, ISO/IEC 27001, etc.).*

## 2. APPLICATION

- 2.1 The CB shall ensure that:
- i) In establishing the audit program the level of integration of the management system(s) is considered.
  - ii) Audit plans cover all areas and activities applicable to each management system standard/specification covered by the scope

стандарт/техникийн тодорхойлолтуудын бүх салбар, үйл ажиллагааг хамарна.

- iii) Аудитын баг бүхэлдээ НМТ-ны аудитын хамрах хүрээг хамарсан менежментийн тогтолцооны стандарт/техникийн тодорхойлолт бүрт хамаарах техникийн салбар тус бүрээр ББ-аас тогтоосон ур чадварын шаардлагыг хангасан байна.
- iv) Аудитыг аудитад хамрагдсан стандарт/техникийн тодорхойлолтуудын аль нэгийг нь эзэмшсэн багийн ахлагч удирдан явуулна.
- v) Аудитын хамрах хүрээнд менежментийн тогтолцооны стандарт/техникийн тодорхойлолтуудыг хамруулан байгууллагын МТ-д бүрэн, үр дүнтэй аудит хийхэд хангалттай хугацаа хуваарилна.

2.1.1 Хоёр ба түүнээс дээш менежментийн тогтолцооны стандарт/техникийн тодорхойлолт(ууд), тухайлбал [A+B+C]-ыг хамарсан НМТ-ны аудитын хугацааг тодорхойлохын тулд ББ нь:

- i) Менежментийн тогтолцооны стандарт/техникийн тодорхойлолт бүрт шаардлагатай аудитын хугацааг тусад нь тооцоолно (холбогдох баримт бичиг ба/эсвэл стандарт тус бүрийн схемийн дүрэмд заасан бүх хүчин зүйлсийг ашиглан, жишээлбэл, IAF MD5, ISO 22003-1, ISO/IEC 27006).
- ii) Тус бүрийн хэсгүүдийн нийлбэрийг (жишээ нь  $T = A + B + C$ ) тооцох замаар НМТ-ны аудитын үргэлжлэх хугацааны  $T$  эхлэх цэгийг тооцоолно.
- iii) Аудит хийхэд шаардагдах хугацааг нэмэгдүүлж, багасгаж болох хүчин зүйлсийг харгалзан эхлэх цэгийг тохируулна (Хавсралт 1-ийг үзнэ үү).

Багасгах хүчин зүйлүүд нь үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

of the audit and are addressed by competent auditor(s).

- iii) The audit team as a whole shall satisfy the competence requirements, established by the CB, for each technical area, as relevant for each management system standard/specification covered by the scope of the audit of an IMS.
- iv) The audit shall be managed by a team leader, competent in at least one of the audited standards/specifications.
- v) Sufficient time is allocated to accomplish a complete and effective audit of the organization's management system for the management system standards/specifications covered by the scope of the audit.

2.1.1 To determine the audit time for an audit of an IMS covering two or more management system standards/specifications, e.g. A + B + C, the CB shall:

- i) Calculate the required audit time for each management system standard/specification separately (applying all relevant factors provided for by the relevant application documents and/or scheme rules for each standard, e.g. IAF MD5, ISO 22003-1, ISO/IEC 27006).
- ii) Calculate the starting point  $T$  for the duration of the audit of the IMS by adding the sum of the individual parts (e.g.  $T = A + B + C$ ).
- iii) Adjust the starting point figure by taking into account factors that may increase or reduce (see Annex 1) the time required for the audit.

The factors for reduction shall include but are not limited to:

a) Байгууллагын менежментийн тогтолцоог нэгтгэсэн хэмжээ.

b) e) Байгууллагын ажилтнууд нэгээс олон удирдлагын тогтолцооны стандарттай холбоотой асуултуудад хариулах чадвар.

c) Менежментийн тогтолцооны нэгээс олон стандарт/техникийн тодорхойлолтод аудит хийх чадвартай аудитор(ууд) байгаа эсэх.

Ихэсгэх хүчин зүйлүүд нь үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

a) Нэг менежментийн тогтолцооны аудиттай харьцуулахад НМТ-ны аудитын төвөгшил.

iv) Байгууллагын менежментийн тогтолцооны нэгдмэл байдлын түвшинд үндэслэн НМТ-ны аудитын үргэлжлэх хугацааг 1-р шат болон дагалдах аудитын нэгдмэл байдлын түвшинг баталгаажуулсаны үндсэн дээр тохируулж болох тухай үйлчлүүлэгчид мэдэгдэх.

2.1.2 НМТ-ны аудит нь хугацааг уртасгаж болох боловч богиноссон тохиолдолд эхлэлийн T (2.1.1 ii) цэгээс 20%-иас хэтрэхгүй байна.

2.1.3 Эхлэх цэгийн тоо, нэмэгдүүлэх, бууруулах үндэслэлийг баримтжуулсан байна.

2.2 Менежментийн тогтолцооны стандарт/техникийн тодорхойлолтуудын аудиттай холбоотой одоо байгаа өргөдлийн баримт бичгүүдийг (жишээ нь, ОУИФ-ын заавал мөрдөх баримт бичиг) НМТ-ны аудитын хөтөлбөр, аудитын төлөвлөгөөг боловсруулахдаа авч үзнэ.

a) The extent to which the organization's management system is integrated.

b) The ability of the organization's personnel to respond to questions concerning more than one management systems standard.

c) The availability of auditor(s) competent to audit more than one management system standard/specification.

The factors for increases shall include but are not limited to:

a) The complexity of the audit of an IMS compared with single management system audits.

iv) Inform the client that the duration of an IMS audit based on the declared level of integration of the organisation's management system may be subject to adjustment on the basis of confirming the level of integration at stage one and subsequent audits.

2.1.2 Audit of an IMS could result in increased time, but where it results in reduction, it shall not exceed 20% from the starting point T (2.1.1 ii).

2.1.3 The starting point figure and justification for increase or reduction shall be documented.

2.2 Existing application documents (e.g. IAF Mandatory Documents) relating to audits of management systems standards/specifications need to be considered when developing audit program and audit plans for an IMS.

2.3 НМТ-ны хамрах хүрээтэй холбоотой менежментийн тогтолцооны стандарт/техникийн тодорхойлолт бүрийн холбогдох бүх шаардлагын хүрээнд аудитыг хийнэ.

2.4 Аудитын тайлангуудыг аудитад хамрагдсан менежментийн тогтолцооны хувьд нэгтгэж эсвэл тусад нь гаргаж болно. Нэгдсэн тайланд дурдсан дүгнэлт бүрийг холбогдох менежментийн тогтолцооны стандарт(ууд)/ техникийн тодорхойлолттой уялдуулан мөрдөх боломжтой.

2.5 Менежментийн тогтолцооны стандарт (ууд)/техникийн тодорхойлолтуудын аль нэгний үл тохирол нь менежментийн тогтолцооны бусад стандарт(ууд)/ техникийн тодорхойлолттой нийцэхэд үзүүлэх нөлөөллийг ББ авч үзнэ.

### **3. АНХДАГЧ АУДИТ БОЛОН БАТАЛГААЖУУЛАЛТ**

#### **3.1 Үйлчлүүлэгчийн өргөдөл**

Үүнд баримт бичгийн интеграцийн түвшин, менежментийн тогтолцооны элементүүд, үүрэг хариуцлагыг багтаасан нэгдмэл байдлын түвшинтэй холбоотой мэдээлэл орно (Хавсралт 1-ийг үзнэ үү).

#### **3.2 1-р шатны аудит**

1-р шатны аудитын үеэр аудитын баг нь НМТ-ны нэгдмэл байдлын түвшинг баталгаажуулна. ББ нь хүсэлт өргөдлийн шатанд өгсөн мэдээлэлд үндэслэн аудитын хугацааг шаардлагатай гэж үзэн, өөрчлөх шаардлагатай.

### **4. МАГАДЛАХ ХЯНАЛТ, ДАВТАН БАТАЛГААЖУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА**

Тогтоосон аудитын үргэлжлэх хугацааг баталгаажуулахын тулд баталгаажуулалтын

2.3 All applicable requirements of each management system standard/specification relevant to the scope of the IMS shall be audited.

2.4 Audit reports can be integrated or separate, with respect to the management systems audited. Each finding raised in an integrated report shall be traceable to the applicable management system standard(s)/specification(s).

2.5 The CB shall consider the impact that a nonconformity found for one of the management system standard(s)/specification(s) has on the compliance with the other management system standard(s)/specification(s).

### **3. INITIAL AUDIT AND CERTIFICATION**

#### **3.1 Client Application**

This shall include information relating to the level of integration, including the level of integration of documents, management system elements and responsibilities (see Annex 1).

#### **3.2 Stage One Audit**

During a Stage One Audit, the audit team shall confirm the level of integration of the IMS. The CB shall review and modify, as necessary, the audit duration that was based on information provided at the application stage.

### **4. SURVEILLANCE AND RECERTIFICATION ACTIVITIES**

The CB shall confirm that the level of integration remains unchanged throughout the certification

мөчлөгийн туршид нэгдмэл байдлын түвшин өөрчлөгдөөгүй гэдгийг ББ баталгаажуулна.

## **5. ТҮДГЭЛЗҮҮЛЭХ, БАГАСГАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ**

Нэг буюу хэд хэдэн менежментийн тогтолцооны стандарт(ууд)/ техникийн тодорхойлолт(ууд)-ын гэрчилгээг түдгэлзүүлэх, багасгах, хүчингүй болгох тохиолдолд ББ нь менежментийн тогтолцооны бусад стандарт(ууд)/ техникийн тодорхойлолтод үзүүлэх нөлөөллийг судална.

*ISO/IEC 17021-1 стандартын хэрэглээ:  
Нэгдсэн менежментийн тогтолцооны  
аудитад ОУИФ-ын заавал мөрдөх баримт  
бичгийн төгсгөл*

cycle to ensure that the established audit durations are still applicable.


## **5. SUSPENSION, REDUCTION, WITHDRAWAL**

If certification to one or more management system standard(s)/specification(s) is subject to suspension, reduction or withdrawal the CB shall investigate the impact of this on the certification to other management system standard(s)/specification(s).

*End of IAF Mandatory Document for the  
Application of ISO/IEC 17021-1 for Audits of  
Integrated Management Systems.*

## ХАВСРАЛТ 1 – АУДИТЫН ХУГАЦААГ БАГАСГАХ

Зураг 1



Зураг 1: Тус зураг нь нэгдсэн аудитын үргэлжлэх хугацаа болон түүний бууруулах хувь (%) хоорондын хамаарлыг харуулна.

**Босоо тэнхлэг:** Байгууллагын менежментийн тогтолцооны нэгдмэл байдлын түвшин (доороос харна уу), үүнд аудитын олон талт асуудалд хандах чадварыг харгалзан үзэх шаардлагатай. Байгууллагын гүйцэтгэлийн олон талыг удирдахын тулд нэг менежментийн тогтолцоог ашигласнаар нэгдсэн менежментийн тогтолцоо бий болдог. Энэ нь дараах байдлаар тодорхойлогддог (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй):

1. Боломжтой бол сайн түвшинд хөгжүүлсэн ажлын зааврыг багтаасан нэгдсэн баримт бичгийн багц.
2. Бизнесийн ерөнхий стратеги, төлөвлөгөөг авч үзсэн менежментийн дүн шинжилгээ.
3. Дотоод аудитын нэгдсэн арга барил.
4. Бодлого, зорилтын нэгдсэн арга барил.
5. Тогтолцооны үйл явцын нэгдсэн арга барил.
6. Сайжруулах үйл ажиллагааны нэгдсэн арга барил (залруулах, сэргийлэх арга хэмжээ; хэмжилт, тасралтгүй сайжруулалт).
7. Удирдлагын нэгдсэн дэмжлэг, үүрэг хариуцлага.

Байгууллагын менежментийн тогтолцоо нь дээрх шалгууруудыг хэр хангаж байгаа эсэхээс хамаарч нэгдмэл байдлын хэмжээг ББ шийднэ.

Мөн

**Хэвтээ тэнхлэг:** Хувиар өгөгдсөн аудитын багийн гишүүдийн мэргэшсэн хэмжээнд хүрэхийн тулд харьцаагаар өгөгдсөн хэмжээг 100-аар үржүүлнэ.

$$\frac{100 ((X1-1) + (X2-1) + (X3-1) + (Xn-1))}{Z(Y-1)}$$

Энэ нь

X1, 2, 3...n нь нэгдсэн аудитын хамрах хүрээнд аудиторын мэргэшсэн стандартын тоо;

Y нь нэгдсэн аудитад хамрагдах менежментийн тогтолцооны стандартын тоо;

Z нь аудиторуудын тоо.

Жишээлбэл:

Гурван өөр менежментийг тогтолцооны стандартыг хамарсан гурван аудиторын нэгдсэн аудитын баг. Нэг аудитор тухайн гурван стандартад мэргэшсэн; нэг аудитор нь хоёр стандарт, нөгөө аудитор нь нэг стандартад мэргэшсэн.

Хэвтээ тэнхлэгт ашиглах хувь хэмжээ нь

$$100 \frac{((3-1) + (2-1) + (1-1))}{3(3-1)} = 50 \%$$

Аудитор бүр нэгээс олон багц аудитын шалгуур/стандартыг хэрэгжүүлэх чадамжтай тул үр ашгийг дээшлүүлж, дээрх томъёогоор хугацааг боломжит хувиар бууруулах боломжтой.

Үүнд:

1. Нэг нээлт, нэг хаалтын хурал хийснээр цаг хугацааг хэмнэнэ.
2. Аудитын нэгдсэн тайлан гаргаснаар цаг хугацааг хэмнэнэ.
3. Материал техникийн хангамж буюу логистикийг оновчтой болгосноор цаг хугацааг хэмнэнэ.
4. Аудиторын багийн хурал дахь цаг хугацааг хэмнэнэ.
5. Баримт бичгийн хяналт зэрэг аудитын түгээмэл элементүүдийг нэгтгэснээр цаг хугацааг хэмнэнэ.

## ANNEX 1 – REDUCTION OF AUDIT TIME

Figure 1




Figure 1: This figure illustrates the reduction (%) in integrated audit duration and its relationship to:

**Vertical axis:** The level of integration of an organization’s management system (see below), which should include a consideration of the auditee’s ability to respond to multi-aspect questions. An Integrated Management System results when an organization uses one single management system to manage multiple aspects of organizational performance. It is characterized by (but not limited to):

1. An integrated documentation set, including work instructions to a good level of development, as appropriate.
2. Management Reviews that consider the overall business strategy and plan.
3. An integrated approach to internal audits.
4. An integrated approach to policy and objectives.
5. An integrated approach to systems processes.
6. An integrated approach to improvement mechanisms (corrective and preventive action; measurement and continual improvement).
7. Integrated management support and responsibilities.

The CB must decide the percentage level of integration based upon the extent to which the organization’s management system meets the above criteria.

And

**Horizontal axis:** The extent, given as a ratio to be multiplied by a factor of 100 in order to achieve the extent given as percentage, to which individual audit team members are qualified:

$$\frac{100 ((X1-1) + (X2-1) + (X3-1) + (Xn-1))}{Z(Y-1)}$$

Where

X1, 2, 3...n is the number of standards for which an auditor is qualified relevant for the scope of the integrated audit;

Y is the number of management system standards to be covered by integrated audit;

Z is the number of auditors.

Example:

An integrated audit team of three auditors covering three different management system standards. One auditor is qualified for all three standards; one auditor is qualified for two of the standards and the other auditor is qualified for one standard.

The percentage figure to be used for the horizontal axis is:

$$100 \frac{((3-1) + (2-1) + (1-1))}{3(3-1)} = 50 \%$$

Due to available competence of each auditor to more than one set of audit criteria/standards, efficiencies are gained and go into the calculation of the possible reduction of time in the formula above. These include:

1. Time saved due to one opening and one closing meeting.
2. Time saved as one integrated audit report is produced.
3. Time saved in optimized logistics.
4. Time saved in auditor team meetings.
5. Time saved auditing common elements simultaneously, e.g. document control.

**Нэмэлт мэдээлэл:**

Тус баримт бичиг болон ОУИФ-ын бусад баримт бичгийн талаарх нэмэлт мэдээллийг ОУИФ-ын гишүүн, нарийн бичгийн дарга нарын газартай холбогдоно уу.

ОУИФ-ын гишүүдийн талаарх мэдээллийг <http://www.iaf.nu>. цахим хуудаснаас авна уу.

**Нарийн бичгийн дарга нарын газар:**

ОУИФ-ын нарийн бичгийн дарга  
Утас: +1 613 454-8159  
И-мейл: [secretary@iaf.nu](mailto:secretary@iaf.nu)

**Further Information:**

For further Information on this document or other IAF documents, contact any member of IAF or the IAF Secretariat.

For contact details of members of IAF see the IAF website <http://www.iaf.nu>.

**Secretariat:**

IAF Corporate Secretary  
Telephone: +1 613 454-8159  
Email: [secretary@iaf.nu](mailto:secretary@iaf.nu)